

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ ХАРИУЦСАН ГАЗРААС
2019 ОНЫ АРВАН ХОЁРДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/2019.11.26 - 2019.12.10/

2019 оны 12 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Биелэлт	Хариуцах албан хаагч	Хувь
1	2	3	4	5	6	7
1	Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах чиглэлээр	Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан тус газартай холбоотой арга хэмжээний биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Биелэлтийг үнэн зөв, бодитой гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндий дэх олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах, нүүлгэн шилжүүлэх дэд ажлын хэсэг 2019.11.28-ны өдөр хуралдаж “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-аас гаргасан саналын талаар хэлэлцэв. Түүнчлэн 2019.12.05-ны өдөр Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудалд “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт ХХК-ийн гүйцэтгэх захирал н.Мэргэнтэй уулзаж ирэгчийн танхимд байрлах тус газрын 3 өрөө, явагчийн танхимд байрлах 1 өрөө /хил хамгаалах байгууллагатай хувааж авах/-ний талаар хэлэлцэж тохирсон.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100
2		Тус газрын 2019 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Тайланг үнэн зөв, бодитой гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Тус газрын 2019 оны 3 дугаар улирал, сүүлийн хагас жил болон жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг боловсруулж байгаа бөгөөд төвөөс өгсөн чиглэлийн дагуу гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст 2019.12.16-ны өдөр хүргүүлэхээр ажиллаж байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	70

1	2	3	4	5	6	7
3		Газрын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэх.	Тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд албан хаагчдаас авч, нэгтгэн Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Захиргаа, Төв аймаг дахь төлөөлөл, боомтод ажиллаж буй 4 ээлжээс хийх ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг авч нэгтгэн тус газрын даргаар батлуулж 2019.11.25-ны өдөр, харин хийсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлтийг байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд авч нэгтгэн 2019.12.11-ний өдөр Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлэв.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Захиргааны ахлах мэргэжилтэн	100
4		Байгууллагын инфографик мэдээнд тусгах статистик тоог гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Тоон мэдээг 2018 онтой харьцуулан гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Гадаадын иргэн, харьяатын газраас гаргадаг инфографик мэдээнд тусгах тус газрын 2019 оны 12 дугаар сарын мэдээг 2018 оны мөн үетэй харьцуулж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст 2019.12.10-ны өдөр хүргүүлэв.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100
5		Байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх.	Албан даалгаврын биелэлтийг үнэн зөв гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Байгууллагын даргын батлан гаргасан 2017 оны 01, 03, 04, 05, 06, 07, 2018 оны 02, 04, 06, 08, 09, 10, 2019 оны 02, 03, 08 дугаар албан даалгаврын биелэлтийг гаргаж 2019.12.03-ны өдөр Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн.	Хяналтын улсын байцаагч	100
6		Төслийн хэмжээнд боловсруулсан тус газрын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг холбогдох байгууллагад санал авахаар хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Төлөвлөгөөний төслийг Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэст санал авахаар хүргүүлсэн байна.	Тус газрын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг төслийн хэмжээнд боловсруулсан гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсээс өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөөг дахин боловсруулж байна.	Ажлын хэсэг	40

1	2	3	4	5	6	7
7	Виз, бүртгэлийн чиглэлээр	Гадаадын иргэнд виз олгох, визний шилжүүлэг хийх, бүртгэл, хасалтын үйлчилгээ үзүүлэх.	Төрийн үйлчилгээг гадаадын иргэнд түргэн шуурхай үзүүлсэн байна.	Нийт 38 орны 164 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс визийн шилжүүлэг 3, нэг удаагийн орох 136, хоёр удаагийн орох 1, олон удаагийн орох 7, нэг удаагийн гарах-орох 10, хоёр удаагийн гарах-орох 4, олон удаагийн гарах-орох 2, нэг удаагийн дамжин өнгөрөх 0, түр ирэгчийн бүртгэл 16, хасалт 21, оршин суух зөвшөөрлийн хасалт 13 байна. Дипломат төлөөлөгчийн газраас алдаатай олгосон визийг шинээр 1 орны 1 гадаадын иргэнд, оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгосон виз 0 байна.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нар	100
8		Монгол Улсын визгүй, хориг арга хэмжээ авагдсан гадаадын иргэнийг буцаах арга хэмжээ авч ажиллах.	Гадаадын иргэний мэдээллийг "ISM" систем дээр шалгаж визгүй, хориг арга хэмжээтэй гадаадын иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаасан байна.	Хөрөнгийн эх үүсвэргүй 1 орны 1 гадаадын иргэн, Монгол Улсад 1 жилд 180 хоногоос дээш хугацаагаар зорчсон 2 орны 18 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан. Гарах визгүй, ААН-ийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр 4 орны 6 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй. Шүүх, ШШГЕГ, прокурорын байгууллагын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нар	100
9	Хяналт шалгалтын чиглэлээр	"Чингис хаан" ОУНБ-д үйл ажиллагаа явуулж буй ААН, байгууллага болон нислэгийн авиа компаниудад хөдөлмөр эрхэлж буй гадаадын	Удирдамж батлуулан хяналт шалгалтыг зохион байгуулж, дүнг тус газрын даргад танилцуулсан байна.	Тус газрын даргын 2019.12.03-ны өдөр баталсан 10/16 дугаар удирдамжийн дагуу мөн өдөр "Чингис хаан" ОУНБ-д үйл ажиллагаа явуулж буй ААН, байгууллага болох нислэгийн авиа компаниудад	Хяналтын улсын ахлах байцаагч, Хяналтын улсын байцаагчнар	100

1	2	3	4	5	6	7
		иргэдийн бичиг баримтад хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах.		хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн бичиг баримтад хяналт шалгалт хийх ажлыг зохион байгууллаа. Хяналт шалгалтад 11 авиа компанид хөдөлмөр эрхэлж байгаа 8 орны 31 гадаадын иргэн хамрагдсан бөгөөд зөрчил илгээгүй болно. Хяналт шалгалт хийсэн талаарх дүнг 2019.12.09-ний өдөр 10/146 дугаар илтгэх хуудсаар тус газрын даргад танилцуулсан.		
10		Зөрчлийн тухай хуулийн дагуу ГИЭЗБТХууль зөрчсөн гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах.	Зөрчил гаргасан гадаадын иргэн, ААН, байгууллагын зөрчлийг шийдвэрлэж, зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.	Бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 5 орны 8 гадаадын иргэнд 1,130,000 төгрөг, 1 аж ахуйн нэгжид /1 орны 1 гадаадын иргэн/ 10,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгөв.	Хяналтын улсын ахлах байцаагч, Хяналтын улсын байцаагч нар	100
11		Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг илрүүлсэн тохиолдолд Монгол Улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулах.	Холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хийсэн байна.	Тус газраас албадан гаргасан гадаадын иргэн байхгүй бөгөөд төвөөс 1 орны 1 гадаадын иргэнийг албадан гаргаж буй үйл ажиллагаанд тус газрын албан хаагчид оролцож, тодорхойлолт үйлдэв.		100
12		Визгүй зорчдог болон хоригт багтсан орны иргэдэд хил дээр тавих хяналтыг сайжруулж ажиллах.	Хил дээр тавих хяналт сайжирсан байна.	Монгол Улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 4 орны 27 гадаадын иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно. Иргэд харилцан зорчих нөхцлийн талаар байгуулсан Засгийн газар хоорондын		100

1	2	3	4	5	6	7
				хэлэлцээрийн дагуу Монгол Улсад зорчин ирж буй 1 орны 3 гадаадын иргэнийг угтан авч буй уригч 3 иргэнээр баталгааны анкет бөглүүлэн хил нэвтрүүлж, уг гадаадын иргэний гарах хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.		
13		Хяналт шалгалтын 2019 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх.	Биелэлтийг үнэн, зөв гаргаж Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна.	Тус газрын хяналт шалгалтын 2019 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж Хяналт шалгалтын газарт 2019.12.11-ний өдөр хүргүүлэв. Нийт 10 чиглэлээр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 100 хувийн биелэлттэй гарсан. Тухайлбал, нийт 9 орны 1230 гадаадын иргэний бичиг баримтад хяналт шалгалт хийж, илрүүлсэн зөрчилд 2,380,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Мөн хөрөнгө оруулагч статусаар оршин суух зөвшөөрөлтэй хөдөлмөр эрхэлж байсан 1 орны 1 гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийг цуцалж олон удаагийн визийг хүчингүй болгосон ба ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан 1 орны 4 гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргасан.	Хяналтын улсын байцаагч	100
14	Хүний нөөц, сургалтын чиглэлээр	Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох ажлыг зохион байгуулах.	ТҮ албан хаагчдын хийсэн ажлыг нэгтгэн гаргаж ур чадварын нэмэгдэл олгуулах саналыг газрын даргад танилцуулж тушаал гаргасан байна.	Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлыг 2019.12.25-ны өдрийн дотор дүгнэж ур чадварын нэмэгдлийг тооцож олгохоор хийсэн ажлыг нэгтгэж байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	40

1	2	3	4	5	6	7
15		Төрийн албаны зөвлөлийн цахим санд албан хаагчдын мэдээллийг шивж оруулан баяжилт хийх.	Тус газрын албан хаагчдын 2019 оны 11 дүгээр сарын нэмэгдлийг оруулсан байна.	Төрийн албаны зөвлөлийн цахим програмд 2019.12.02-ны өдөр тус газрын нийт албан хаагчдын энэ оны 11 дүгээр сард авсан нэмэгдлийн талаарх мэдээллийг оруулсан болно.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100
16		Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар албан хаагчдад сургалт зохион байгуулах.	Жендэрийн тухай ойлголт, эрх тэгш байдлын талаарх ойлголтыг бататгасан байна.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар 2019.12.03-ны өдөр Хууль сахиулахын их сургуулийн багш, Хууль зүйн ухааны доктор /Ph.D/, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Ж.Нямдулам тус газрын 14 албан хаагчдад мэдээлэл хийв. Албан хаагчид хүний нөөцийн бодлого, хөдөлмөрийн харилцааг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байран дахь бэлгийн дарамт, жендэрийн эрх тэгш байдал ямар хэлбэрээр илэрдэг, бодлогын баримт бичиг, жендэрт суурилсан хүчирхийлэл, хаана үйлдэгддэг, урьдчилан сэргийлэх аргын талаарх мэдлэгээ дээшлүүлэв. Сургалт зохион байгуулахад 100,000 төгрөг зарцуулав.		100
17		Төрийн жинхэнэ албан хаагчийн 2019 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг дүгнэх.	Холбогдох журмын дагуу дүгнэсэн байна.	Төвөөс өгсөн чиглэлийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн 2019 оны 1, 2, 3 дугаар улирлын гүйцэтгэлийн тайланг нөхөн гаргуулж, жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг 2019.12.10-ны өдрөөр тасалбар болгон авч дүгнэн төвд 2019.12.13-ны өдөр хүргүүлэхээр ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар албан хаагчид гүйцэтгэлийн тайлангаа боловсруулж байна.	Ажлын хэсэг	40

1	2	3	4	5	6	7
18		Тус газрын сургалтын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх.	Биелэлтийг үнэн, зөв гаргаж Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна.	Агаарын замын боомт хариуцсан газраас 2019 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний биелэлтийг 2019.12.11-ний өдөр гаргаж Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу нийт 21 төрлөөс сургалт зохион байгуулахаар тусгасан бөгөөд биелэлт 100 хувьтай гарсан. Гадаад сургалтанд 4 албан хаагч, дотоодын 45 сургалтанд давхардсан тоогоор 528 албан хаагчийг хамруулсан.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100
19		Тус газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх.	Биелэлтийг үнэн, зөв гаргаж Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна.	ГИХГ-ын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх Агаарын замын боомт хариуцсан газрын 2019 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж 2019.12.11-ний өдөр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу 18 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд биелэлт 100 хувьтай гарсан.		100
20	Санхүү, хангалт, үйлчилгээний чиглэлээр	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр авлагагүй ажиллах.	Төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэн ажилласан байна.	Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 558,383,800 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 354,903,202 төгрөг, ажил олгогч болон даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэл 43,681,229 төгрөг, Хан-Уул дүүрэгт цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 23,595,257 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллав.	Ахлах нягтлан бодогч, Нярав	100

1	2	3	4	5	6	7
21		Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв гарган тогтоосон хугацаанд тайлагнах.	Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг дараа сарын 5, төсвийн гүйцэтгэлийн тайланг дараа сарын 2-ны өдрийн дотор гаргаж төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоо бүрдсэн байна.	Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган 2019.12.05-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн өссөн дүнгээр 83,455,042 төгрөгөөр тооцоо нийлэв. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2019.12.02-ны өдрийн дотор гарган Хан-Уул дүүргийн төрийн сангаар баталгаажуулан Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Мэдээгээр 537,268,000 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 474,408,643 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан.	Ахлах нягтлан бодогч, Нярав	100
22		Эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулах.	Тус газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн 2019 оны жилийн эцсийн тооллогыг зохион байгуулсан байна.	Тус газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/19 дүгээр “Эд хөрөнгийн тооллого явуулах тухай” тушаалын дагуу ажлын хэсэг гарч энэ сарын 05-10-ны өдрүүдэд тооллогыг зохион байгуулсан.	Ажлын хэсэг	100
23		Үнэт цаасны тооцоо, авто машин ашиглалтын болон шатах тослох материалын тооцоог хугацаанд нь гаргаж, бүртгэл хөтлөн ажиллах.	Бүртгэл тооцоо хугацаандаа чанартай хийгдсэн байна.	Албан хаагчдад энэ сард шийтгэлийн хуудас, визийн хуудас олгоогүй болно. Түүнчлэн авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөв.	Ахлах нягтлан бодогч, Нярав	100
24		Төсвийн хүрээнд худалдан авалт хийх, албан хаагчдын ажиллах нөхцлөөр хангаж ажиллах.	Шаардлагатай бараа материалын худалдан авалт хийж шаардах хуудасны дагуу бараа материалыг тухай бүр нь гаргаж өгсөн байна.	Бараа материалд өссөн дүнгээр 20,173,770 төгрөгийн худалдан авалтыг хийж шаардах хуудасны дагуу албан хаагчдад өгсөн байна. Түлш шатах тослох материалд өссөн дүнгээр 22,000,000 төгрөгийн зарцуулалт гаргаж тайлагнасан байна.		100

1	2	3	4	5	6	7
25		Албан хэрэгцээнд ашиглаж буй суурин утас, шуудангийн болон боомтод байрлах албан хаагчдын ажлын байрны түрээсийн төлбөр тооцоог нэхэмжлэхийн дагуу шийдвэрлэх.	Нэхэмжлэхийн дагуу тухайн байгууллагын холбогдох дансруу шилжүүлэн өглөг авлагагүй ажиллана.	Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт өссөн дүнгээр 2,819,870 төгрөг, байрны түрээс 40,404,000 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс уруу шилжүүлсэн болно.	Ахлах нягтлан бодогч, Нярав	100
26		Татварын улсын тэмдэгтийн хураамж, хүү, торгуулийн тайланг гаргаж тооцоо нийлэх.	Хяналтын улсын байцаагч нараас тайланг авч тулган, сар бүрийн 5-ны дотор төвд хүргүүлсэн байна.	Хүү торгууль өссөн дүнгээр 108,070,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж өссөн дүнгээр 574,966,630 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн.		100
27		Бараа материалын тайлан, кассын тайланг тухай бүр гаргах.	Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн ажилласан байна.	Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан.		100
28		Газрын албан хаагчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийх.	Албан хаагчдын НДД, ЭМД-ын дэвтэрт бичилт хийж нийгмийн даатгалын байцаагчаар НДД-ийг баталгаажуулсан байна.	Тус газрын 28 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.		100
29		Нийгмийн даатгал, татварын тайланг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх.	Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэст хүргүүлсэн байна.	Тус газар нийгмийн даатгал, татварын тайланг гаргаж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Татварын хэлтэст хүргүүлсэн болно.		100

1	2	3	4	5	6	7
30	Өргөдөл, гомдлын чиглэлээр	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, гомдол гаргах бүрт бүртгэл хөтлөн, холбогдох албан хаагчид хүргүүлж, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлэх.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлсэн байна.	Агаарын замын боомт хариуцсан газарт ирсэн өргөдөл, гомдлыг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, уг өргөдөл, гомдолд “Бүртгэл-хяналтын карт” хөтөлж, газрын даргад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хүргүүлэн ажилладаг болно. Энэ сард иргэн, ах ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас ирсэн өргөдөл, гомдол байхгүй бөгөөд мэдээг 2019.12.10-ны өдөр Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100
31	Бичиг хэрэг, архивын үйл ажиллагааны чиглэлээр	Газарт ирсэн, явсан албан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах.	Ирсэн, явсан бичгийн бүртгэлийг хөтөлжсөн хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу тус газарт ирсэн нийт 10 албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, хариутай 5 албан бичигт “Бүртгэл-хяналтын карт” хөтлөн, газрын даргад танилцуулан цохолт хийлгэж, холбогдох албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллав. Хариутай албан бичгийн шийдвэр-лэлтийн талаар “Бүртгэл-хяналтын карт”-д тэмдэглэв. 6 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.		100
32		Тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэх.	Ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэсэн байна.	Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд ирсэн 10, явсан 6 албан бичиг, тус газрын даргын батлан гаргасан 3 тушаал, сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг скайнердаж цахим хэлбэрт шилжүүлэв.		100

1	2	3	4	5	6	7
33		Хэвлэмэл хуудасны зарцуулалтын бүртгэлийг хөтлөн тус газрын даргад танилцуулах.	Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолын хэрэгжилт хангагдсан байна.	Агаарын замын боомт хариуцсан газрын өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаг хэвлэмэл хуудасны зарцуулалтын тайланг гаргаж тус газрын даргад танилцуулж ажиллалаа. Албан бичгийн А4, А5, тодорхойлолтын А5 хэвлэмэл хуудас, тус газрын даргын тушаалын хэвлэмэл хуудасны 2019.11.01-2019.11.30-ний өдрийн зарцуулалтын тайланг 2019.11.29-ний өдөр гаргаж тус газрын даргад танилцуулав.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100
34		Архивын өрөөний чийг, дулааныг хэмжиж бүртгэл хөтлөх.	Хэмжилтийг өдөр бүр хийж, бүртгэл хөтөлсөн байна.	Тус газрын архивын өрөөний чийг, дулааныг ажлын өдрүүдэд өдөр бүр хэмжиж дэвтэрх бичилт хийн ажиллав. Дулаан 20-25С, чийг 20-30RH байна.		100
35		Тус газраас архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 2019 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх.	Биелэлтийг үнэн, зөв гаргаж Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна.	ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газраас архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 2019 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж Захиргаа, удирдлагын газарт 2019.12.11-ний өдөр хүргүүлсэн. Нийт 21 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд биелэлт 100 хувьтай гарсан.		100
36	Мэдээллийн технологийн чиглэлээр	Сүлжээний тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах.	Ирсэн дуудлагын дагуу засвар үйлчилгээг хийж хэвийн ажиллагаанд оруулсан байна.	Сүлжээ болон компьютерийн чиглэлээр нийт 14 удаагийн дуудлага хүлээн авч засварлалаа. Тус газрын 11 компьютерын хэвийн ажиллагаа, сүлжээний хэвийн үйл ажиллагааг шалгав. Зөөврийн компьютер 1, суурин компьютер 6 форматлан шаардлагатай програмууд суулгасан.	Сүлжээний инженер	100

1	2	3	4	5	6	7
				<p>Мөн ил гарсан сүлжээний утсыг далдалсан. Дотоод сүлжээ энэ хугацаанд хэвийн ажилласан ба “ISM” програмын шинэчлэлийг дотоод сүлжээний компьютерт суулгасан.</p>		
37	Олон нийттэй харилцах чиглэлээр	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг тухай бүр оруулж, иргэд хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлэх.	Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж, мэдээг үнэн зөв оруулсан байна.	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг шивж оруулсан. Тухайлбал, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл болно.	Ахлах нягтлан бодогч	

1	2	3	4	5	6	7
38		Тус газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах.	Тус газрын сарын төлөвлөгөө, биелэлт, тайлан, өргөдөл, гомдлын мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.	Тус газрын мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудсанд 2019 оны 11 дүгээр сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайлан, зохион байгуулсан сургалт, өргөдөл, гомдлын мэдээ, 12 дугаар сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг байршуулж олон нийтийг мэдээллээр хангав.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100
39	Цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллагын хамтран ажиллах журмын хэрэгжилтийг хангах 2019	Төв аймгийн нутаг дэвсгэрт оршин сууж буй гадаадын иргэний мэдээлэлийг сүлжээнээс шүүж цагдаагийн хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлэх, хэсгийн төлөөлөгч нараас сумдад оршин сууж байгаа гадаад иргэдийн судалгааг авч харилцан мэдээлэл солилцох	Холбогдох сүлжээнээс шүүлт хийж, сумдын багт бүртгэлтэй оршин сууж байгаа гадаад иргэдийн талаар харилцан үнэн, зөв мэдээллээр хангасан байна.	Төв аймгийн нутаг дэвсгэрт оршин сууж буй гадаадын иргэний мэдээллийг сүлжээнээс шүүж мэдээ Төв аймгийн цагдаагийн газрын ахлах мөрдөн н.Батмөнхөд 2019.12.11-ний өдөр хүргүүлсэн.	Төв аймаг дахь ахлах мэргэжилтэн	100
40	оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын чиглэлээр	Зөрчлийн тухай хуульд заагдсан зөрчил гаргасан гадаадын иргэний зөрчлийн талаарх мэдээлэл, судалгаа	Мэдээлэл, судалгааг харилцан солилцсон байна.	Төв аймгийн нутаг дэвсгэрт энэ онд төлөвлөгөөт 14, төлөвлөгөөт бус 2 хяналт шалгатын ажлыг зохион байгуулав. Холбогдох мэдээг Төв аймгийн цагдаагийн газрын ахлах мөрдөн н.Батмөнхөд 2019.12.11-ний өдөр хүргүүлсэн.		100
41		Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэний мэдээлэл	Мэдээлэл, судалгааг харилцан солилцсон байна.	Төв аймгийн нутаг дэвсгэрт албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэний мэдээлэл, харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон иргэний мэдээлэл, гадаадаас ажиллах хүч авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын		100
42		Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллаа сэргээн	Мэдээлэл, судалгааг харилцан солилцсон байна.			100

1	2	3	4	5	6	7
		тогтоолгосон иргэний мэдээлэл, гадаадаас ажиллах хүч авч ажиллуулж байгаа ААН, байгууллагын мэдээлэл		мэдээллийг 2019 оны 4 дүгээр улирлын байдлаар гаргаж 2019.12.11-ний өдөр цагдаагийн байгууллагын ахлах мөрдөн н.Батмөнхөд хүргүүлэв.	Төв аймаг дахь ахлах мэргэжилтэн	
43		Журмын хэрэгжилтийн талаарх мэдээллийг, хоёр байгууллагын удирдлагад танилцуулах	Үнэн зөв мэдээллээр хангагдсан байна	Цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллагын хамтран ажиллах журмын хэрэгжилтийг хангах 2019 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж тус газрын даргад 2019.12.11-ний өдөр танилцуулсан.		100
44	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр	“Амин дэм, витаминжуулалтын аян” зохион байгуулах.	Албан хаагчдыг амин дэмээр хангаж ажиллах, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэгдсэн байна.	ГИХГ-ын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх тус газрын 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан хаагчдыг дархлаа тэтгэх амин дэмээр 2019.12.09-ний өдөр хангав.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн	100

Төлөвлөсөн: 44

Биелсэн: 40

Хагас биелсэн: 4

Биелээгүй: 0

Хувь: 96